



Монгол Улсын
төрийн туг (далбаа)
1911 он



Хичээлийн сэдэв:

МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1911-1924



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

1911, 1921 оны хувьсгалын үеийн гадаад, дотоод нөхцөл байдал, шалтгаан, ач холбогдол, сургамжийг харьцуулан тодорхойлох



Харьцуулан
шинжлэх

Баримтыг
тайлбарлах

Он тоолол



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ

1911, 1921 оны хувьсгалууд харьцуулж үзье



Үзүүлэлт	1911	1921
Удирдагчид	VIII Богд Жавзандамба Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд	Д. Бодоо, С. Данзан, Д. Сүхбаатар
Хувьсгалын урьдах нөхцөл	ШЗБ, Манжийн эрхшээл, Тусгаар тогтнол	1917 Октябрын эргэлт, 1919 Хятадын цэргийн дэглэм
Гол үйл явдал	1911.12.29	1921. 07.11
Шинж чанар	Үндэсний эрх чөлөөний хувьсгал	Үндэсний ардчилсан хувьсгал
Ач холбогдол	Тусгаар тогтнолоо олж авсан	Тусгаар тогтнолоо дахин сэргээсэн



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ

Хувьсгалууд	1911 оны хувьсгал	1921 оны хувьсгал
Орос улсаас тусламж гуйхаар явсан төлөөлөгчид	Чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд , гүн Хайсан	С.Данзан, Д.Бодоо, Д.Чагдаржав, Д.Лосол, Д.Догсом, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан
Хувьсгалыг удирдсан байгууллага	ХХБХТЭСГ, дарга Түшээ гүн Чагдаржав	МАН, АТЗГ дарга Д.Чагдаржав
Хувьсгалын шийдвэрлэсэн асуудал	Манжийн эрхшээлээс гарсан.	Харийн цэргийн дэглэмээс гарсан.
Төр засаг	Шашин төрийг хослон баригч Богд хаан	Ардын эрхт хэмжээт цаазат засаг



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ

Үзүүлэлт	1911	1921
Улс төр	<ul style="list-style-type: none">- Улсын дээд, доод хурал- Жинхэнэ ардын дагаж явах дүрэм- Байнгын цэрэг	<ul style="list-style-type: none">- Ардын засгийн газар- Тангарагийн гэрээ- Хамжлагын харилцаа- Үндсэн хууль
Эдийн засаг	<ul style="list-style-type: none">- 1913 онд гаалийн дүрэм- Монголор нийгэмлэг- Худалдаа, арилжаа- МАА, Газар тариалан	<ul style="list-style-type: none">- Хятад, Орос, бусад, (Даашинхүү)- Хоршоо- Татвар- Мөнгөн тэмдэгт
Оюун санаа	<ul style="list-style-type: none">- 1912 оноос албан сургууль,- Шинэ толь, Нийслэл хүрээний сонин бичиг	<ul style="list-style-type: none">- Судар бичгийн хүрээлэн- 1924 Улсын номын сан, Архив,- 1924 Ардыг гэгээрүүлэх яам



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1911-1919



1911 оны 12 сарын 29-ний өдрийн яг ёслол болсон цаг мөчид Ховд, Улиастай, Алтанбулаг, Ерөө зэрэг олон газар, Монголын өнцөг булан бүрт хүмүүс Хүрээний зүг хандаж, нэгэн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясчээ. Үүнийг үзсэн гадаадынхан олон Монголчуудын **нүд** урьд өмнө хэзээ ч ингэж **очтон гэрэлтэж** байсныг хараагүй гэж бичсэн байдаг.



“... Улсын сүрийг бадруулан хаан эзний өмнө, шашин төрийн өмнө зүтгэхэд хялбарыг эрэхгүй, бэрхээс зайлахгүй, эдүгээгийн байгуулсан төрийн тул энэхүү батлан тогтоосон тангараг сахилыг **нүдний цөцгий, зүрхний тольт** мэт хичээнгүйлэн хайрлана.

Төрийн түшмэдийн өрдөг тангарагаас.



Төрийн алба хаагчдыг алба үүрэгтээ **хайнга хандсан**, хуурмаг үйл ажиллагаа явуулсан бол **зэрэг, хэргэм бууруулах, ташуур жанчих, 35 дөнгө дөнгөлөх, жилийн пүнлүү хасах, малаар торгох** шийтгэл оноож байжээ. Тэрчлэн Улсын хурлаас **хоцрох, таслах** тохиолдолд тогтоосон хэмжээний зулын **шар тосоор** торгодог байлаа.



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1911-1919

Монголын тусгаар тогтнолтой холбоотой зарим чухал гэрээ хэлэлцээрүүд



1912.03.10

ДИУ

ДИУ-ын нутаг дэвсгэр нь 22 муж, Ар, Өвөр Монгол, Түвэд, Хөх нуураас бүрдэнэ.

1912.09.03

Найрамдлын гэрээ

Орос улс Гадаад Монголыг автономит эрхтэй оршин тогтнох, хятадын цэрэг оруулахгүй байхад туслах, мөн Монголд худалдаа хийх

1913.02.04

Монгол –Төвөд

Монгол, Төвөдийн шинэ тогтсон улсаа харилцан хүлээн зөвшөөрөх, шарын шашныг мандуулах

1913.11.08

Бээжингийн тунхаг

Орос улс, Монгол дахь хятадын эзэн эрхийг хүлээн зөвшөөрсөн бол, Хятад улс Гадаад Монголын автономитыг хүлээн зөвшөөрчээ.

1915

Хиагтын гэрээ

Гадаад Монгол Хятадын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрнө. Гадаад Монгол нь Автономит эрхтэй бөгөөд Хятадын газар нутгийн нэгэн хэсэг болохыг Хятад, Орос 2 тулган хүлээлгэв.



Богд хаан

Улсын дээдхурал
Улсын доод хурал

Ерөнхий сайд
Бүгд ерөнхийлөн
шийтгэх яам

Шашин төрд
туслах яам

Дотоод яам
Да лам
Цэрэнчимэд

Гадаад яам
Чин ван
Ханддорж

Цэргийн яам
Гүн
Гомбосүрэн

Сангийн яам
Гүн
Чагдаржав

Шүүх яам
Ван Намсрай

Гаалийн
яам

Эрдэнэ
Шанзудбын
яам

Засагт хан
аймаг

Сайн ноён
хан аймаг

Түшээт хан
аймаг

Сэцэн хан
аймаг

Дөрвөд
далай хан
аймаг

Дөрвөд Үнэн
Зоригтаймаг

Богдын
Их шавь


Харъяа олон хошуу, шавь, сум, арван

Отог,
арван

Улсын дээд хурал-Яамдын тэргүүн, дэд сайд, ван бэйл, бэйс, гүн засгууд, бүгдийн дарга нар

Улсын доод хурал-Яамдын дэс түшмэл, эх зохиогч түшмэл, Эрдэн шанзадбын яам, 4-н аймгийн жанжин, суурин жасаанаас 1 түшмэл

Ардын Засгийн газар 1921 оны VII.10



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1911-1919

Аж ахуй, эдийн засгийн сэргээх чиглэлээр

Мал сүргээ өсгөн үржүүлэх, эрүүлжүүлэх, газар тариалан хөгжүүлэх, өвс хадлан бэлтгэх бодлого явуулав.

1913 онд 30-аад зүйлтэй гэрээ байгуулж, Оросын малын эмч нар Монголын төв ба хойд нутагт ажиллажээ.

Цагаан алт, очир алмас, эрдэнийн чулууны орлогын 20-50%-ийг, чулуун нүүрсний 5-10%-ийг татварлах болжээ.



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1911-1919

СОЁЛ БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1912 онд 47 сурагчтай
анхны иргэний сургууль

Орон нутагт 60 гаруй
бага сургууль хичээллэх
болжээ.

Орос хэл бичгийн
сургууль нээж, Хаант
Орос улсад хүүхэд
залуусаа явуулан сургаж
эхлэв.

Тогтмол хэвлэлүүд бий
болсон.
Шинэ толь 1913,
Нийслэл хүрээний сонин
бичиг 1915

“Зарлигаар тогтоосон
Монгол Улсын шаштир”
1918

Эрх чөлөөгөө тэмцэн
олсон монгол түмний
үндэсний үзэл сэргэж,
аман зохиол, урлагийн
хөгжилд шинэ дэвшил
гарав.



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1911-1919

- Дараах ардын дууны шүлэг ямар үйл явдлын тухай өгүүлж байна вэ? Энэ шүлэг аль үед холбогдох вэ?

“Магнаг дээлтэй сайдууд гуай
Манийгаа худалдаж гялайв уу?
Богц богц мөнгөөр
Богдоо худалдаад гялайв уу?
Дэнс дэнс мөнгөөр
Дэлхийгээ худалдсан сайдууд гуай
Уут уут мөнгөөр
Улсаа худалдсан сайдууд гуай”



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1911-1919

1917 оны 2 сарын хувьсгалаар Орост хаант засгийг түлхэн унагаж, улмаар большевикууд засгийн эрхэнд гарав.

Орост иргэний дайн дэгдсэн.

Оросын хаант төр үгүй болсон тул “Хиагтын гэрээ” хүчингүй гэх болов.

Чэнь И энэхүү нөхцөл байдлыг ашиглан Монголын автономит эрхийг цуцалж, Хятадад нэгтгэх бодлого явуулж эхэлжээ.

Чэн И
Сюй Шүжан

1919 оны 10-р сарын сүүлээр автономит эрхээсээ татгалзах асуудлыг Дээд, Доод хурлаар хэлэлцүүлэв.



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1921-1924

Монгол Улс үндэсний ардчилсан өөрчлөлтийн бодлого явуулахыг чухалчилж байв.

Хэмжээт
цаазат
хаант улс

АЗГ-с эзэн хамжлагын харилцааг халах түүхэн шийдвэр гаргав. Ноёд тайж нарын хамжлага захирах эрхийн тамгыг хурааж авчээ.

Өртөө, улааг цэгцэлж, гадаадын худалдаачдад төлөх өрийг хүчингүй болгон, алба татварын бодлогыг өөрчилж, харийнхны мэдэлд байсан үйлдвэр, уурхайн газруудыг улсын болгох арга хэмжээ авчээ.

1923 онд “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх баримт бичгийг батлав.



МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ 1921-1924

СОЁЛ БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1921.11-р сард 3
жилийн бага
сургууль

Дотоод яаманд
“Сургуулийн хэлтэс”

Орчин үеийн
эмнэлэг байгуулах
арга хэмжээг авч
байв.

Судар бичгийн
хүрээлэн байгуулав

1922 Р. Ч.
Эндрюсийн
экспедиц,
1923 К. Козловын
шинжилгээний анги



ГЭРИЙН ДААЛГАВАР



Даалгаврын
хувилбарууд

Эрдэм шинжилгээний өгүүлэл уншиж, түүнийгээ
тайлбарлах



1911, 1921 хувьсгалын сонирхсон асуудлын хүрээнд
бүтээлч даалгавар хийгээрэй.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА